

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
	2.1. Оршил.....	3
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
	2.8.1. Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	8
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал.....	9
	3.1 Худалдан авах ажиллагааны талаар	10
	3.2 Үндсэн хөрөнгийн тооллогын талаар	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
	4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
	4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
	4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
	4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
	4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



МОНЦАМЭ АГЕНТЛАГИЙН ДАРГА
Б.ГАНЧИМЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.28 № 06/358
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу МОНЦАМЭ агентлагийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

МОНЦАМЭ агентлагийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар МОНЦАМЭ агентлагийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

МОНЦАМЭ агентлагийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг МОНЦАМЭ агентлагийн дарга Б.Ганчимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үндсэн хөрөнгийн бүртгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу МОНЦАМЭ агентлагийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

МОНЦАМЭ агентлагийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэсэн.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 10 дугаар сарын 03-наас 2019 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Шонхор үнэлгээ Аудит” ХХК-ийн аудитор З.Эрдэнэжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

МОНЦАМЭ агентлаг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 1/47 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

МОНЦАМЭ агентлагийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

МОНЦАМЭ агентлаг нь улс оронд болон дэлхий дахинд болж буй үйл явдлын тухай мэдээ мэдээллийг цуглуулан шуурхай түгээх, Монгол Улсын түүх соёл, хөгжил дэвшлийг гадаадын олон нийтэд таниулан сурталчлах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Монгол Улсын төр, засгийн удирдлага ба төв байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, өргөн олон нийтийг улс орны дотоод амьдралын шуурхай мэдээллээр хангах,
2. Гадаад ертөнц, олон хэмжээнд болж байгаа үйл явдлын мэдээллээр хангах,
3. Монгол Улсын гадаад, дотоод бодлого, дотоодын үйл явдал, улс орны хөгжил дэвшлийг гадаадад мэдээлэх, сурталчилан таниулах явдал болно.

МОНЦАМЭ агентлагийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

МОНЦАМЭ агентлагийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль

Тайлант хугацаанд МОНЦАМЭ агентлагийн бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2012 онд батлагдсан бөгөөд Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

МОНЦАМЭ агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

МОНЦАМЭ агентлагийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Ординат ХХК-ийн "Винница" програм хангамж ашигладаг байна.

МОНЦАМЭ агентлагийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаж үзэхэд Монцамэ агентлангийн даргын 2012 оны 32 дугаар тушаалаар баталсан "Дотоод хяналт, шалгалтын журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн, дотоод хяналтын баг, бүрэлдэхүүнийг томилон ажиллуулдаг тул дотоод хяналтыг үр нөлөөтэй гэж үзэж байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад МОНЦАМЭ агентлагийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлангийн нийт орлогын 1 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвийн санхүүжилтээр гол үйл ажиллагаагаа явуулдагтай холбоотой юм.

Гүйцэтгэх үе шатанд МОНЦАМЭ агентлагийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувиар буюу 17,769.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 11 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	81,396.6	
2	Албан шаардлага өгсөн	1	1,625.6	
	Дүн	3	83,022.2	

2.8.1. Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1.Цалингийн талаар

Тайлант оны 2,3,7 дугаар саруудын цалин илүү тооцож олгосноос шалтгаалан 33 ажилтанд авлага өглөгийн тооцоо үүсгэсэн, мөн 1 ажилтанд 9 хоногийн цалин илүү тооцож 354.7 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” гэж заасантай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 5 сарын 08-ны өдрийн 100 дугаар тушаалаар батлагдсан “Дэлгэрэнгүй бүртгэл ЦХ-1” маягыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгох, өр авлагын тооцоог хийх, Нийгмийн даатгалын болон ХХОАТ-ын тайланг залруулах,

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц асуудал илрээгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

МОНЦАМЭ агентлагийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,719,535.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,713,781.4 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь телефон утасны хэрэглээнд хязгаарлалт тогтоосон, сэтгүүлчид орон нутагт аж ахуйн нэгжийн зардлаар ажилласантай холбоотой байна.

Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 185,000.0 мянган төгрөгийг 10,419.4 мянган төгрөгөөр давуулан биелсэн нь вебсайтын хандалтыг нэмэгдүүлж сонин хэвлэлийг цахимаар худалдан авах ажлыг амжилттай хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

МОНЦАМЭ агентлаг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд Төсөвт/гүйцэтгэл хэсэгт 9 мэдээлэл оруулахаас 7 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авах хэсэгт 5 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл, бусад хэсэгт 6 мэдээлэл оруулахаас 6 мэдээлэл, нийт 20 мэдээлэл оруулахаас 16 мэдээллийг 1-12 саруудад оруулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2,904.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөнөөс 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь биелүүлэн ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид МОНЦАМЭ агентлагийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

МОНЦАМЭ агентлагийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь МОНЦАМЭ агентлагийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Худалдан авах ажиллагааны талаар

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 297,250.5 мянган төгрөгийн хэвлэхийн тоног төхөөрөмж худалдан авах төсөв батлагдсан боловч худалдан авах ажиллагааг зохион байгуулж нээлттэй тендер шалгаруулах явцад биет бус хөрөнгө буюу ашиглаж байсан хуучин веб сайтын сайжруулалтад 79,500.0 мян төгрөгийг зарцуулсан байна. Тоног төхөөрөмжийн болон сайтын сайжруулалтыг 1 тендерээр зарлаж гүйцэтгэлийг хүлээн авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.11-т "Захиалагч тухайн жилд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мөрдөж ажиллах бөгөөд төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаар тайлбар, үндэслэлийг худалдан авах ажиллагааны тайланд тодорхой тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Тухайн жилд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

3.2 Үндсэн хөрөнгийн тооллогын талаар

Үндсэн хөрөнгийн тайлангийн үлдэгдлийг биет байдлаар түүвэрлэн тулган тоолж үзэхэд "Номын фонд" гэсэн нэртэйгээр 1,896.6 мянган төгрөгийн номыг бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Хөрөнгийн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, номыг нэр төрөл нэгжийн үнээр салгаж бүртгэх.

Аудитын асуудлын бүртгэлийг МОНЦАМЭ агентлагийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,156,006.60</u>	<u>74,410,394.77</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	17,006,199.80	35,026,413.03
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		196,666.72
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	17,006,199.80	34,301,326.00
335	Бусад авлага	-	528,420.31
3351	Байгууллагаас авах авлага		528,420.31
35	БАРАА МАТЕРИАЛ	31,149,806.80	39,383,981.74
351	Түүхий эд материал	3,246,006.80	7,194,661.87
35110	Тусгай зориулалттай материал	3,246,006.80	7,194,661.87
354	Хангамжийн материал	27,903,800.00	32,189,319.87
35410	Бичиг хэргийн материал	14,086,434.00	18,279,015.00
35420	Аж ахуйн материал	6,666,655.00	6,659,875.00
35430	Сэлбэг хэрэгсэл	67,000.00	67,000.00
35440	Түлш, шатах тослох материал	760,000.00	1,071,818.87
35470	Бусад хангамжийн материал	6,323,711.00	6,111,611.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>212,212,875.30</u>	<u>671,841,210.47</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	212,212,875.30	671,841,210.47
391	Газар		
392	Биет хөрөнгө	200,484,875.30	578,861,550.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	734,904,171.00	274,077,529.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	665,579,671.79	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,955,000.00	66,955,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	52,705,000.14	62,205,000.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	843,326,318.97	1,055,182,248.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	744,839,920.68	782,730,903.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,194,463.02	52,759,967.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	32,817,085.08	30,969,330.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,160,000.00	3,745,440.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	2,160,000.00	
39217	Ном	2,046,600.00	2,046,600.00
393	Биет бус хөрөнгө	11,728,000.00	92,979,659.96
39301	Програм хангамж	19,660,000.00	99,160,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	7,932,000.00	20,978,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө		14,797,660.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>260,368,881.90</u>	<u>746,251,605.24</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>725,087.03</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	725,087.03
413	Өглөг	-	725,087.03

МОНЦАМЭ агентлагийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41310	Ажилчидтай холбогдсон өглөг		725,087.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>260,368,881.90</u>	<u>745,526,518.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	260,368,881.90	745,526,518.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	908,982,864.52	923,780,524.52
51101	Өмч: - төрийн	908,982,864.52	923,780,524.52
512	Хуримтлагдсан үр дүн	-718,705,197.78	-456,076,975.31
51210	Өмнөх үеийн үр дүн	-718,705,197.78	-705,653,025.71
51220	Тайлант үеийн үр дүн		249,576,050.40
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,091,215.16	277,822,969.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>260,368,881.90</u>	<u>746,251,605.24</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,369,311,082.45	1,776,939,576.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	239,848,082.45	225,153,788.08
120	Нийтлэг татварын бус орлого	203,556,872.45	213,365,788.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	203,556,872.45	213,365,788.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	184,502,568.45	192,612,892.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,054,304.00	20,752,896.00
122	Тусламжийн орлого	36,291,210.00	11,788,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	36,291,210.00	11,788,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,129,463,000.00	1,551,785,788.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,124,963,000.00	1,531,785,788.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,124,963,000.00	1,234,535,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		297,250,488.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,500,000.00	20,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		20,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,394,054,341.98	1,527,363,525.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,394,054,341.98	1,527,363,525.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,345,959,086.88	1,500,034,780.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	918,679,860.73	996,822,428.25
210101	Үндсэн цалин	915,775,140.73	996,822,428.25
210102	Нэмэгдэл	2,904,720.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,195,300.61	122,156,930.60
210201	Тэтгэврийн даатгал	66,932,867.25	81,429,810.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,774,998.35	10,175,672.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,569,175.83	8,147,867.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,906,774.87	2,040,021.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,011,484.31	20,363,560.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,616,000.00	36,407,500.00
210301	Гэрэл, цахилгаан	14,214,019.00	15,027,847.95
210302	Түлш, халаалт	15,427,212.53	13,028,168.91
210303	Цэвэр, бохир ус	3,974,768.47	8,351,483.14
2104	Хангамж, бараа материалын зардал	35,674,384.18	54,618,801.21
210401	Бичиг хэрэг	5,129,011.97	3,720,150.00
210402	Тээвэр, шатахуун	5,364,400.00	7,233,181.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,510,075.21	34,499,838.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,080,000.00	1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,590,897.00	7,725,632.00
2105	Нормативт зардал	-	132,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		132,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,781,450.00	8,885,390.00

МОНЦАМЭ агентлагийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	2,781,450.00	8,885,390.00
2107	Томилолт, зочны зардал	5,034,700.00	15,614,700.00
210701	Гадаад албан томилолт		10,917,203.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,034,700.00	4,697,497.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	166,290,985.24	158,823,655.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,162,510.00	60,437,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	700,210.00	700,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,800.00	283,774.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	295,500.00	842,000.00
210807	Газрын төлбөр	228,000.00	230,296.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	88,634,965.24	94,329,925.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,686,406.12	106,572,774.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,790,100.00	13,581,036.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,896,306.12	92,991,738.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,095,255.10	27,328,745.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,496,000.00	13,905,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,496,000.00	13,905,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,599,255.10	13,423,745.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,599,255.10	13,423,745.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(24,743,259.53)</u>	<u>249,576,050.40</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(24,743,259.53)</u>	<u>249,576,050.40</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,318,960,760.65</u>	<u>1,747,205,173.46</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	189,497,760.65	195,419,385.46
120	Нийтлэг татварын бус орлого	189,497,760.65	195,419,385.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	189,497,760.65	195,419,385.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	189,497,760.65	195,419,385.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,129,463,000.00	1,551,785,788.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,124,963,000.00	1,531,785,788.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,124,963,000.00	1,234,535,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		297,250,488.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,500,000.00	20,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		20,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,318,960,760.65</u>	<u>1,449,954,685.46</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,318,960,760.65	1,449,954,685.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,270,865,505.55	1,422,625,940.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	918,796,841.34	998,348,882.43
210101	Үндсэн цалин	918,796,841.34	998,348,882.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,173,600.00	119,979,200.00
210201	Тэтгэврийн даатгал	64,603,390.54	79,978,135.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,355,320.72	9,994,267.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,196,680.24	8,002,613.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,851,476.88	2,003,652.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,166,731.62	20,000,533.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,616,000.00	36,407,500.00
210301	Гэрэл, цахилгаан	14,214,019.00	15,027,847.95
210302	Түлш, халаалт	15,427,212.53	13,028,168.91
210303	Цэвэр, бохир ус	3,974,768.47	8,351,483.14
2104	Хангамж, бараа материалын зардал	38,639,254.21	69,023,423.08
210401	Бичиг хэрэг	8,786,730.00	17,994,114.00
210402	Тээвэр, шатахуун	5,424,400.00	7,040,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,510,075.21	34,499,838.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,080,000.00	1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,838,049.00	8,049,471.00
2105	Нормативт зардал	132,600.00	132,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132,600.00	132,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,313,200.00	18,195,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	1,813,200.00	10,195,640.00

МОНЦАМЭ агентлагийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	5,334,700.00	16,119,700.00
210701	Гадаад албан томилолт		10,917,203.00
210702	Дотоод албан томилолт		205,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,334,700.00	4,997,497.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,984,410.00	150,575,458.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,162,510.00	60,437,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	700,210.00	700,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,800.00	283,774.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,277,500.00	1,995,000.00
210807	Газрын төлбөр	228,000.00	230,296.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	85,346,390.00	84,928,728.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,874,900.00	13,843,536.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,874,900.00	13,843,536.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,095,255.10	27,328,745.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,496,000.00	13,905,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	13,905,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,096,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,400,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,599,255.10	13,423,745.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,599,255.10	13,423,745.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>297,250,488.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	297,250,488.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	297,250,488.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	297,250,488.00
222001	Тоног төхөөрөмж		297,250,488.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(297,250,488.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	908,982,864.52	70,091,215.16	-693,961,938.25	285,112,141.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	908,982,864.52	70,091,215.16	-693,961,938.25	285,112,141.43
C07	Тайлант үеийн үр дүн			-24,743,259.53	-24,743,259.53
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	908,982,864.52	70,091,215.16	-718,705,197.78	260,368,881.90
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	908,982,864.52	70,091,215.16	-743,448,457.31	260,368,881.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	908,982,864.52	70,091,215.16	-718,705,197.78	260,368,881.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	14,797,660.00	207,731,753.84	13,052,172.07	235,581,585.91
D08	Тайлант үеийн үр дүн			249,576,050.40	249,576,050.40
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	277,822,969.00	-456,076,975.31	745,526,518.21

МОНЦАМЭ агентлагийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,309,963,000.00	849,937,990.96	1,719,535,300.00	1,713,781,428.41	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,309,963,000.00	849,937,990.96	1,419,535,300.00	1,416,530,940.41	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,267,467,000.00	807,441,990.96	1,417,535,300.00	1,414,625,940.41	100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	919,756,600.00	459,873,326.75	999,825,600.00	998,348,882.43	100
210101	Үндсэн цалин	808,945,500.00	459,873,326.75	837,773,800.00	998,348,882.43	119
210102	Нэмэгдэл	10,829,000.00	-	15,236,200.00	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,982,100.00	-	146,815,600.00	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,173,600.00	101,173,600.00	119,979,200.00	119,979,200.00	100
210201	Тэтгэврийн даатгал	101,173,600.00	101,173,600.00	119,979,200.00	119,979,200.00	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,616,000.00	33,616,000.00	36,407,500.00	36,407,500.00	100
210301	Гэрэл, цахилгаан	13,414,500.00	14,214,019.00	14,206,000.00	15,027,847.95	106
210302	Түлш, халаалт	16,315,000.00	15,427,212.53	11,115,000.00	13,028,168.91	117
210303	Цэвэр, бохир ус	3,886,500.00	3,974,768.47	11,086,500.00	8,351,483.14	75
210304	Байрны түрээс					
2104	Хангамж, бараа материалын зардал	38,643,200.00	38,639,254.21	69,733,700.00	69,023,423.08	99
210401	Бичиг хэрэг	11,782,100.00	8,786,730.00	11,782,100.00	17,994,114.00	153
210402	Тээвэр, шатахуун	4,364,900.00	5,424,400.00	5,040,000.00	7,040,000.00	140
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,876,200.00	18,510,075.21	47,942,200.00	34,499,838.08	72
210404	Ном, хэвлэл					
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ар	1,090,600.00	1,080,000.00	1,440,000.00	1,440,000.00	100
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,529,400.00	4,838,049.00	3,529,400.00	8,049,471.00	228
2105	Нормативт зардал	132,600.00	132,600.00	132,600.00	132,600.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132,600.00	132,600.00	132,600.00	132,600.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,813,200.00	1,813,200.00	10,200,000.00	10,195,640.00	100
210604	Урсгал засвар	1,813,200.00	1,813,200.00	10,200,000.00	10,195,640.00	100
2107	Томиллолт, зочны зардал	5,334,700.00	5,334,700.00	16,119,700.00	16,119,700.00	100
210701	Гадаад албан томилолт	4,817,400.00	5,334,700.00	8,300,000.00	10,917,203.00	132
210702	Дотоод албан томилолт	517,300.00	-	819,700.00	205,000.00	25
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			7,000,000.00	4,997,497.00	71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165,122,200.00	164,984,410.00	151,287,600.00	150,575,458.90	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,174,900.00	74,162,510.00	60,700,000.00	60,437,450.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00	2,000,000.00	2,000,000.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	805,900.00	700,210.00	705,900.00	700,210.00	99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	297,000.00	289,800.00	300,000.00	283,774.00	95
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,285,000.00	2,277,500.00	2,000,000.00	1,995,000.00	100
210807	Газрын төлбөр	228,000.00	228,000.00	230,300.00	230,296.00	100
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	85,351,400.00	85,346,390.00	85,351,400.00	84,928,728.90	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,874,900.00	1,874,900.00	13,849,400.00	13,843,536.00	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,874,900.00	1,874,900.00	13,849,400.00	13,843,536.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,496,000.00	42,496,000.00	2,000,000.00	1,905,000.00	95
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,496,000.00	42,496,000.00	2,000,000.00	1,905,000.00	95
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал			2,000,000.00	1,905,000.00	95
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,096,000.00	10,096,000.00			
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,400,000.00	32,400,000.00			
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	300,000,000.00	297,250,488.00	99
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	300,000,000.00	297,250,488.00	99
222001	Тоног төхөөрөмж			300,000,000.00	297,250,488.00	99
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,309,963,000.00	1,308,861,505.55	1,719,535,300.00	1,713,781,428.41	100
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,124,963,000.00	1,119,363,744.90	1,534,535,300.00	1,518,362,042.95	99
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,124,963,000.00	1,119,363,744.90	1,534,535,300.00	1,518,362,042.95	99
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	185,000,000.00	189,497,760.65	185,000,000.00	195,419,385.46	106
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,000,000.00	189,497,760.65	180,000,000.00	195,419,385.46	109
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	-	5,000,000.00	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00	
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	108.00	108.00	108.00	108.00	
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	2.00	2.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	100.00	100.00	100.00	100.00	
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	6.00	6.00	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	108.00	-	108.00	-	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	20.00		15.00		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	88.00		93.00		

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/168/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын	МОНЦАМЭ агентлаг		мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тоног төхөөрөмжийн болон сайтын сайжруулалтыг 1 тендерээр зарлаж гүйцэтгэлийг хүлээн авсан.	79,500.0	Зөвлөмж өгсөн	МОНЦАМЭ агентлагийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
2	Үндсэн хөрөнгийн тайлангийн үлдэгдлийг биет байдлаар тулган тоолж үзэхэд “Номын фонд” гэсэн нэртэйгээр бөөн дүнгээр бүртгэсэн байна.	1,896.6	Зөвлөмж өгсөн	МОНЦАМЭ агентлагийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
3	Тайлант оны 2,3,7 дугаар саруудын цалин илүү тооцож олгосноос шалтгаалан 33 ажилтанд авлага өглөгийн тооцоо үүсгэсэн, мөн 1 ажилтанд 9 хоногийн цалин илүү тооцож	1,625.6	Албан шаардлага өгсөн	МОНЦАМЭ агентлагийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
	Дүн	83,022.20			

